



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,

Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,

Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,

E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.02.20 № 3/260

танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Барилга, хот байгуулалтын яамны аппаратын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Барилга, хот байгуулалтын яамны аппаратын удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Барилга, хот байгуулалтын яамны аппаратын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн бодитой, шударга илэрхийлэгдсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



С.ЭНХЗАЯА



БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ АППАРАТЫН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

САГ-ын дарга, Тэргүүлэх аудитор
С.Энхзаяа
Утас: 261663
Цахим хаяг: enkhzayas@audit.gov.mn

Аудитын менежер: Н.Золзаяа
Утас: 260512
Цахим хаяг: zolzayan@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Ганбилэг
Аудитор: Ж.Болормаа
Шинжээч: Б.Баярмаа

Утас: 260512
Цахим хаяг: ganbilegd@audit.gov.mn
bolormaaj@audit.gov.mn
bayarmaab@audit.gov.mn

ТАБ-ын хаяг: УБ хот,
Чингэлтэй дүүрэг
ЗГ-ын 4-р байр
Цахим хуудас: www.audit.mn

2016 оны 2 дугаар сар

Аудитын тайлан

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Материаллаг байдал
6. Дотоод хяналт
7. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
8. Шилэн дансны мэдээлэл
9. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
10. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
11. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар
12. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар
13. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
17. Зөвлөмж
18. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Нэг. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Барилга, хот байгуулалтын яамны аппаратын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд /САГ-2017/192/СТА-ТШЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

Барилга, хот байгуулалтын яамны аппаратын 2016 оны санхүүгийн тайлан Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, Сангийн сайдын баталсан холбогдох заавар журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, шударга бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Барилга, хот байгуулалтын яамны аппаратын 2016 оны жилийн санхүүгийн тайланг ТНБД-ын 2017 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн 03/234 дүгээрр албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

Санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 1 дүгээр сарын 25-наас 2 дугаар сарын 25-ны өдрийн хооронд хийхээр төлөвлөн Үндэсний аудитын газрын САГ-ын ахлах аудитор Д.Ганбилэг, аудитор Ж.Болормаа, шинжээч Б.Баярмаа гүйцэтгэж, тайланг хуулийн хугацаанд тус яамны аппаратын удирдлагад гардуулна.

Хоёр. Байгууллагын хууль, эрх зүйн орчин

Барилга, хот байгуулалтын яам нь холбогдох хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгүүдийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллаж байна. Тухайлбал,

- 2016 оны төсвийн тухай хууль
- Монгол улсын засгийн газрын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Барилгын тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль

- Шилэн дансны тухай хууль
- Архивын тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Төрийн аудитын тухай хууль
- Авилгатай тэмцэх тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- ХХОАТатварын тухай хууль зэрэг байна.

2016 оны 2 дугаар сарын 5-ны өдөр Барилгын тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсан байна.

Гурав. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа

Барилга, хот байгуулалтын яамны эрхэм зорилго нь барилга, хот байгуулалт, газрын харилцаа, барилга, барилгын материалын үйлдвэрлэл, орон сууц, нийтийн аж ахуйн бодлогын үр нөлөөг дээшлүүлэх замаар хүн амын ая тухтай, аюулгүй амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

Яам нь үйл ажиллагааны дор дурдсан тэргүүлэх чиглэлтэй ажилладаг байна. Үүнд,

- Хот байгуулалт, газрын харилцаа, геодези, зураг зүйн салбарыг хөгжүүлэх бодлого боловсруулж хэрэгжүүлэх;
- Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлого боловсруулж хэрэгжүүлэх;
- Орон сууц, нийтийн аж ахуйн салбарыг хөгжүүлэх бодлого боловсруулж хэрэгжүүлэх;
- Салбарын санхүү, эдийн засгийн төлөвлөлт, хөрөнгө оруулалтын үр дүнг дээшлүүлэх;
- Салбарын хамтын ажиллагааг өргөжүүлж, гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих;
- Төрийн захиргаа, хүний нөөц, хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын тогтолцоог хэрэгжүүлэх, удирдлагаар хангах.

Дээрх зорилт, үйл ажиллагааг хэрэгжүүлэхийн тулд Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасны дагуу Төрийн нарийн бичгийн дарга Төсвийн шууд захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

БХБЯ-ны аппаратын 2016 оны төсвийг Сангийн яамны төрийн сангаас олгож, хяналт тавьж ажилласан байна.

Тус яамны үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан болно.

Дөрөв. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн

Аудит хийхэд УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд болон Сангийн сайдын баталсан холбогдох заавар, журмыг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Барилга, хот байгуулалтын яамны аппаратын 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд нягтлан бодох бүртгэлийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоож тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдаас түүвэрлэн аудитын нарийвчилсан горим, сорил 37-ыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан мөрдөж ажилласан байна.

Санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах, тайлан гаргах ажиллагааг санхүүгийн “Acolous” програмаар гүйцэтгэдэг байна.

Санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа мэдээллийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд “бага” буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэж үзсэн байна. /ТАБ-СТА-В-2/

Тав. Материаллаг байдал

Аудитын төлөвлөх ба гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг АОУС 320-ын дагуу тодорхойлсон болно.

2016 оны санхүүгийн тайлангийн материаллаг байдлын үнэлгээг санхүүгийн үр дүнгийн тайлангаарх нийт зардлын 2% буюу 43.3 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд тодорхойлсон материаллаг байдлын түвшин нь төлөвлөлтийн үед тодорхойлсноос материаллаг хэмжээний зөрүүгүй тул нэмэлт горим, сорил хэрэгжүүлэх шаардлагагүй гэж үзэв.

Зургаа. Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

ТНБД-ын 2016 оны Б/122 дугаар тушаалаар тус яамны бүтэц, зохион байгуулалт шинэчлэгдэж Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар 5 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байгаа бөгөөд 2016 онд нийт 34 ажил хийхээр төлөвлөснөөс гадаадын зээл тусламжаар хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдэд дотоод аудит хийж нийт 23 зөвлөмж өгч ажилласан байна.

Дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед “дунд” гэж тооцсон боловч дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

Долоо. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар

БХБЯ-ны аппаратын 2016 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

2016 оны төсвийн гүйцэтгэлийг төлөвлөгөө болон өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулахад дараах байдалтай байна.

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он		Зөрүү	
		Төсөв	Гүйцэтгэл	Өмнөх оны гүйцэтгэлээс	Төлөвлөгөө нөөс
Урсгал зардал	2,354.9	1,808.2	1,792.6	(562.3)	(15.6)
Бараа, ажил үйлчилгээний зардал	2,191.2	1,647.8	1,634.6	(556.6)	(13.2)
Урсгал шилжүүлэг	163.7	160.4	158.0	(5.7)	(2.4)
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	2,357.5	1,808.2	1,795.3	(562.2)	(12.9)

Дээрх хүснэгтээс харахад 2016 онд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр өмнөх оноос 562.2 сая төгрөгөөр, төлөвлөгөөнөөс 12.9 сая төгрөгөөр буурсан байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар төсвийн урсгал санхүүжилтийн орлогоос гадна бараа үйлчилгээний орлого 100.1 сая төгрөг тайлагнасан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар урсгал зардал 1,792.6 сая төгрөг тайлагнагдсанаас 55 хувь буюу 995.1 сая төгрөг нь цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал байна.

Найм. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 5,6,7 дугаар зүйл, Засгийн газрын 2014 оны “Журам батлах тухай” 384 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор ТНБД-ын 2016 оны А/79

дүгээр тушаалаар байгууллагын цахим хуудас болон Шилэн дансны цахим хуудсанд оруулах мэдээлэл, тавих хугацаа, хариуцах албан тушаалтны жагсаалт баталсан байна. Үүний дагуу Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас цахим хуудсанд байрлуулсан мэдээллийг төрийн сан дахь харилцах дансны гүйлгээ, байгууллагын даргын тушаал шийдвэр, гэрээ зэрэг холбогдох баримт бичигтэй тулган шалгаж илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч ажилласан байна.

Ес. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу уламжлалт болон хяналтын 37 эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв. Аудитын явцад дараах гол эрсдэлүүдийг хянаж, үр дагаврыг тодорхойлов. Үүнд,

- Баримтгүй болон баримтын бүрдэлгүй орлого, зарлагын гүйлгээг хүлээн зөвшөөрч данс бүртгэлд тусгасан байх
- Мөнгөн хөрөнгийг захиран зарцуулах, гүйцэтгэх, хянах тогтолцоо алдагдсан байх
- Бүртгэлд байгаа хөрөнгө байгууллагын эзэмшилд биетээр байхгүй байх
- Хөрөнгийг ТӨБЗГ-ын шийдвэргүйгээр данснаас хассан, шилжүүлсэн эсвэл борлуулсан байх
- Холбогдох хууль, тогтоол, журам, заавар зөрчсөн байх
- Зардлын зүйл ангиудыг батлагдсанаас зөрүүтэй зарцуулсан байх зэрэг

Дээрх эрсдэлүүдийн хүрээнд гарсан зөрчлүүдийг асуудлын бүртгэлээр яамны удирдлагад танилцуулж, менежментийн захидлаар зөвлөмж өгөв.

Арав. Гол онцлог гүйлгээний талаарх тайлбар

2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, урьдчилж гарсан зардал, үндсэн хөрөнгө, улсын төсвийн санхүүжилтийн орлого, зардал зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Тайлант хугацаанд гарсан гол онцлог гүйлгээг дурдвал:

- 2016 онд тохиосон Шинэ үеийн барилгын салбар үүсч хөгжсөний 90 жилийн ойн арга хэмжээний үйл ажиллагаатай холбоотой нийт 15.7 сая төгрөгийн гүйлгээ гарсан байна.

Арав нэг. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар

2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн алдаа, зөрчил болон удирдлагын анхаарал хандуулах гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

1. Санхүүгийн үр дүнгийн тайланд 2016 онд олгосон урсгал санхүүжилтийн 5.1 сая төгрөгийг орлогын ангилал буруу бүртгэсэн, Өмчийн өөрчлөлтийн тайлангийн хуримтлагдсан элэгдэл дансны өмнөх үеийн үр дүнг 2.8 сая төгрөгийн зөрүүтэй тайлагнасан нь НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.9-д "... санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн зөв мэдээллээр хангах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулга хийв.

2. ТӨБЗГ-ын зохих шийдвэргүй балансаас балансад 30.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлсэн байна. Мөн өмнөх сайдын эд хөрөнгийн ашиглалтын картанд бүртгэлтэй 2015 оны 9 сарын 15-нд худалдан авсан 3.4 сая төгрөгийн үнэтэй зөөврийн компьютер /Dell/ нь байгууллагын хөрөнгөд бодитоор тоологдоогүй байна.

Шийдвэрлэсэн нь: Менежментийн захидлаар зөвлөмж өгсөн.

3. Эд хогшил худалдан авах зардлын төсөв 14.9 сая төгрөгөөр батлагдсан боловч 5.3 сая төгрөг илүү зарцуулсан, баяр ёслолын арга хэмжээний зардлын ангиллаас 3.9 сая төгрөгийн үнэтэй хөрөнгө худалдан авсан байна.

Шийдвэрлэсэн нь: Менежментийн захидлаар зөвлөмж өгсөн.

4. ТНБД-ын үүргийг түр орлон гүйцэтгэгч нь 2016 оны 5 сарын 31-ний өдөр "Зууны гүүр" ХХК-тай "Эрсдэлтэй ажлын байрны судалгаа хийх" гэрээг байгуулсан байна. Гэрээний нийт үнийн дүн 9.9 сая төгрөгөөс урьдчилгаа 6.5 сая төгрөгийг шилжүүлсэн боловч гэрээг дүгнээгүй, гэрээнд заасан ажлыг гүйцэтгээгүй, гүйцэтгэгч нь эргэж холбогдох боломжгүй болсон байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тавьж барагдуулах

5. Мөн 2016 оны 3 сарын 10-ны өдөр хуульч Т.Цэен-Ойдовтой Хууль зүйн туслалцаа үзүүлэх тухай 25 дугаартай гэрээ хийж 9.8 сая төгрөгийг шилжүүлсэн боловч 15-ны өдөр 26 дугаартай нэг ижил ажлын даалгавартай 9.5 сая төгрөгийн гэрээг дахин байгуулсан байна. Гэрээний нийт үнийн дүн 19.3 сая төгрөгийг бүрэн төлсөн боловч гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй, гэрээний 3.6-д заасны дагуу хуульч Т.Цэен-Ойдов үүргээ биелүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тавьж барагдуулах

6. 2015 оны санхүүгийн тайлангийн аудитаар Хязгаарлалттай санал дүгнэлт болон зөрчил арилгах албан шаардлага авсан Санхүү, эдийн засгийн хэлтсийн ажилтнуудад цаг хугацаанд нь тайлангаа гаргасан гэсэн үндэслэлээр цалингийн урамшуулалд 4.2 сая төгрөг олгосон нь тушаалын үндэслэлд дурдсан Сангийн сайдын 2012 оны 294 дүгээр тушаалын 5.1-д

заасан заалт, 2006 оны 292 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн өмчит аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодох бүртгэлийн ажилтныг шагнах журам”-ын заалттай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тавьж барагдуулах

7. Батлагдсан цалингийн төсвөөс хэмнэгдсэн 25.7 сая төгрөгийг харьяалагдах татварын хэлтэс болон нийгмийн даатгалын хэлтэст шилжүүлж урьдчилж гарсан зардлаар бүртгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Менежментийн захидлаар зөвлөмж өгсөн.

Арван хоёр. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар

2016 оны санхүүгийн тайланд залруулагдаагүй материаллаг бус дараах алдаа гарсан байна.

- Санхүүгийн үр дүнгийн тайланд шатахууны картын урамшууллын орлого 318.5 мянган төгрөгийг тайлагнаагүй байгаа нь тайлант хугацаанд гарсан бүх ажил гүйлгээг бүртгэсэн, орхигдуулсан зүйлсгүй иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Арван гурав. Анхаарал татахуйц бусад чухал асуудал

2016 оны санхүүгийн тайлангийн аудитаар анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй байна.

Арван дөрөв. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

2016 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

Арван тав. Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 46.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэнээс 7.9 сая төгрөгийн алдааг залруулж, 30.1 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тавьж, бусад зөрчилд асуудлын бүртгэлээр болон менежментийн захидлаар зөвлөмж өгөв.

Арван зургаа. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

2015 оны санхүүгийн тайланд УАГ аудит хийж 2 зөвлөмж, 1 албан шаардлага өгсөн бөгөөд зөвлөмжийн биелэлтийг 2017 оны 1 сарын 20-ны өдрийн 03/230 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна. ТНБД-ын 2016 оны А/53 дугаар тушаалаар зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөө батлан ажилласан байна.

Арван долоо. Зөвлөмж

2016 оны санхүүгийн тайлангийн аудитаар 3 зөвлөмж өгч менежментийн захидлыг хавсаргав.

Арван найм. Зөрчилгүй санал дүгнэлт

Барилга, хот байгуулалтын яамны аппаратын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлангууд болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн бодитой, шударга илэрхийлэгдсэн байна.



YAG
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ АППАРАТЫН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

АСУУДАЛ 1

Үндсэн хөрөнгийн ашиглалтын талаар

АСУУДАЛ 2

Батлагдсан төсвийн гүйцэтгэлийн талаар

АСУУДАЛ 3

Төсвийн хэмнэлтийн зарцуулалтын талаар

БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ АППАРАТЫН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Төсвийн захирагчид зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгасан болно.

Төрийн аудитын байгууллагын энэхүү зөвлөмж та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Төсвийн шууд захирагчийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ АППАРАТЫН
2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

АСУУДАЛ 1: Хөрөнгийн шилжилт хөдөлгөөний талаар

Ажиглалт

ТӨБЗГ-ын зохих шийдвэргүй
балансаас балансад 30.2 сая
төгрөгийн үндсэн хөрөнгийг
шилжүүлсэн байна. Мөн өмнөх
сайдын эд хөрөнгийн ашиглалтын
картанд бүртгэлтэй 2015 оны 9 сарын
15-нд худалдан авсан 3.4 сая
төгрөгийн үнэтэй зөөврийн
компьютер /Dell/ нь байгууллагын
хөрөнгөнд бодитоор байхгүй байгаа
нь санхүүгийн тайлангийн дуусгавар
болсон өдөр байгууллагын хөрөнгө,
өр төлбөр бодитой оршин байх гэсэн
батламж мэдэгдлийг хангахгүй
байна.

Зөвлөмж

Төрийн болон орон нутгийн өмчийн
тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 2-д
“Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан эд
хөрөнгийг худалдах, шилжүүлэхэд энэ
хуулийн 29, 30 дугаар зүйлд заасан
эрх бүхий байгууллагын зөвшөөрөл
авна” гэсэн заалтыг дагаж мөрдөх

Хөрөнгийн тооллогыг бодитой хийх,
дутсан хөрөнгийн асуудлыг
шийдвэрлэх

Эрсдэл

Төсвийн хөрөнгийг үргүй зарцуулах,
санхүүгийн хяналт сулрах

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитаар илэрсэн асуудлын
бүртгэлийг танилцуулсан болно

БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ АППАРАТЫН
2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

АСУУДАЛ 2: Батлагдсан төсвийн гүйцэтгэлийн талаар

Ажиглалт

Эд хогшил худалдан авах зардлын төсөв 14.9 сая төгрөгөөр батлагдсан боловч 5.3 сая төгрөг илүү зарцуулсан, баяр ёслолын арга хэмжээний зардлын ангиллаас 3.9 сая төгрөгийн үнэтэй хөрөнгө худалдан авсан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2-т “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

Зөвлөмж

Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах, төсвийг зориулалтын дагуу зарцуулах

Эрсдэл

Батлагдсан төсвийг зориулалтын бусаар, үр ашиггүй зарцуулах

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитаар илэрсэн асуудлын бүртгэлийг танилцуулсан болно

БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ АППАРАТЫН
2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

АСУУДАЛ 3: Төсвийн хэмнэлтийн зарцуулалтын талаар

Ажиглалт

Батлагдсан цалингийн төсвөөс хэмнэгдсэн 25.7 сая төгрөгийг харьяалагдах татварын хэлтэс болон нийгмийн даатгалын хэлтэст шилжүүлж урьдчилж гарсан зардлаар бүртгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Зөвлөмж

Тухайн төсвийн жилд гарсан орлого, зарлагыг зөв бүртгэж, авлага өр төлбөр үүсгэхгүй, төсвийг бодитой төсөвлөх

Эрсдэл

Төсвийн төлөвлөлт бодитой бус байх, төсвийн гүйцэтгэлийн тайлан алдаатай илэрхийлэгдэх

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитаар илэрсэн асуудлын бүртгэлийг танилцуулсан болно

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	591,287,412.60	325,991,364.03
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	2,688,678.00	-
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	2,688,678.00	-
31110	Төгрөг	2,688,678.00	
31120	Гадаад валют		
31130	Нэмэлт санхүүжилт		
31140	Касс арилжааны банк		
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	-
3121	Төгрөг	-	-
31211	Төрийн сангийн харилцах		
31212	Монгол банкин дахь харилцах		
31213	Арилжааны банк дахь харилцах		
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах		
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах		
31216	Нэмэлт санхүүжилтийн арилжааны банк		
3122	Гадаад валют	-	-
31221	Төрийн сангийн харилцах		
31222	Монгол банк дахь харилцах		
31223	Арилжааны банк дахь харилцах		
31224	Бусад төсөл, нөөцийн харилцах		
31400	Замд яваа мөнгөн хөрөнгө		
31500	Хадгаламж		
32	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-
321	Үнэт цаас	-	-
32110	Төгрөг		
32120	Гадаад валют		
33	АВЛАГА	-	1,188,000.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага		
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага		
33300	Татаас, санхүүжилтийн авлага		
33400	Зээлийн хүүгийн авлага		
33401	Дансны авлага /ТӨҮГ/		
33402	Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/		
335	Бусад авлага	-	1,188,000.00
3351	Байгууллагаас авах авлага		
3352	Хувь хүмүүсээс авах авлага		1,188,000.00
336	Зээлийн авлага	-	-
3361	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	-	-
33611	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөвт олгосон		
33612	Хувь хүмүүст олгосон зээл		
33613	Сургалтын төрийн сангийн зээлийн авлага		
33614	Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд олгосон зээл		
33615	Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээл		
3362	Гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн авлага	-	-
33621	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөвт олгосон		
33622	Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд олгосон зээл		
33623	Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээл		
34	УРЬДЧИЛГАА	576,599,420.00	305,764,176.23

34100	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөвт олгосон		
34200	Төсөвт байгууллага		
34300	Тусгай зориулалтын сан		
34400	Төрийн өмчийн үйлдвэр, аж ахуйн газар	576,599,420.00	305,764,176.23
34500	Хувийн хэвшлийн үйлдвэр, аж ахуйн газар		
34600	Урьдчилж гарсан зардал		
3471	Урьдчилгаа тооцоо	-	-
34711	Бараа материал бэлтгэх урьдчилгаа		
34712	Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа		
34713	Цалингийн урьдчилгаа		
34714	Томилолтын урьдчилгаа		
35	БАРАА МАТЕРИАЛ	11,371,814.60	8,070,549.80
351	Түүхий эд материал	-	-
35110	Тусгай зориулалттай материал		
35130	Эм боох материал		
35200	Дуусаагүй үйлдвэрлэл		
35300	Бэлэн бүтээгдэхүүн		
354	Хангамжийн материал	11,371,814.60	8,070,549.80
35410	Бичиг хэргийн материал	1,656,165.00	5,185,224.00
35420	Аж ахуйн материал	8,761,613.60	1,776,535.80
35430	Сэлбэг хэрэгсэл	233,750.00	
35440	Түлш, шатах тослох материал		
35450	Барилгын засварын материал		
35460	Хүнсний материал		
35470	Бусад хангамжийн материал	720,286.00	1,108,790.00
35500	Биологийн хөрөнгө		
35600	Мал амьтад		
36	НӨӨЦИЙН БАРАА	627,500.00	10,968,638.00
36100	Барааны нөөц		
36200	Үрийн нөөц		
36300	Тэжээлийн нөөц		
36400	Шатахууны нөөц		
36500	Буудайн нөөц		
36600	Бусад нөөц	627,500.00	10,968,638.00
36700	Бусад санхүүгийн хөрөнгө /ТӨҮГ/		
36800	Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/		
36900	Борлуулах зорилгоор эзэмшиж буй бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/		
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	412,063,153.61	260,163,326.05
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-
371	Урт хугацаат хадгаламж	-	-
37110	Төгрөг		
37120	Гадаад валют		
372	Үнэт цаас	-	-
37210	Төгрөг		
37220	Гадаад валют		
373	Урт хугацаат зээл	-	-
3731	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	-	-
37311	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөвт олгосон		
37312	Хувь хүмүүст олгосон зээл		
37313	Сургалтын төрийн сангийн зээлийн авлага		
37314	Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд олгосон зээл		
37315	Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээл		
3732	Гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн авлага	-	-
37321	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөвт олгосон		
37323	Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд олгосон зээл		

37324	Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээл		
37330	Урт хугацаат хөрөнгө оруулалт-зам, гүүр		
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	412,063,153.61	260,163,326.05
391	Газар		
392	Биет хөрөнгө	403,500,403.61	255,317,576.05
39201	Барилга, байгууламж, орон сууц		
39202	Хуримтлагдсан элэгдэл		
39203	Авто-тээврийн хэрэгсэл	418,039,080.83	440,704,878.83
39204	Хуримтлагдсан элэгдэл	(240,765,886.31)	(303,967,406.76)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	467,831,457.76	375,707,227.76
39206	Хуримтлагдсан элэгдэл	(322,009,594.75)	(327,777,185.52)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	279,150,585.78	286,689,215.78
39208	Хуримтлагдсан элэгдэл	(199,090,434.17)	(216,194,265.36)
39209	Зам, гүүрийн байгууламж		
39210	Хуримтлагдсан элэгдэл		
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж		
39212	Хуримтлагдсан элэгдэл		
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс		
39214	Бусад үндсэн хөрөнгө	7,505,408.00	7,505,408.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(7,160,213.53)	(7,350,296.68)
39216	Дуусаагүй барилга, байгууламж		
39217	Ном		
393	Биет бус хөрөнгө	8,562,750.00	4,845,750.00
39301	Програм хангамж	16,153,510.00	16,153,510.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(8,809,510.00)	(11,401,510.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	4,500,000.00	4,500,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(3,281,250.00)	(4,406,250.00)
394	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	-	-
39401	Биологийн хөрөнгө /ТӨҮГ/		
39402	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө /ТӨҮГ/		
39403	Хойшлогдсон татварын хөрөнгө /ТӨҮГ/		
39404	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө /ТӨҮГ/		
39405	Бусад эргэлтийн бус хөрөнгө /ТӨҮГ/		
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,003,350,566.21</u>	<u>586,154,690.08</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>4,966,790.00</u>	<u>-</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	4,966,790.00	-
411	Богино хугацаат үнэт цаас	-	-
4111	Төгрөг	-	-
41111	Бонд		
41112	Бусад үнэт цаас		
41113	Бондын хөнгөлөлт		
4112	Гадаад валют	-	-
41121	Бонд		
41122	Бусад үнэт цаас		
41123	Бондын хөнгөлөлт		
412	Богино хугацаат зээлийн өглөг	-	-
4121	Төгрөг	-	-
41211	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв		
41212	Хувь хүмүүст олгосон зээл		
41213	Сургалтын төрийн сангийн зээлийн өглөг		
41214	Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн зээл		
41215	Монгол банк		
41216	Арилжааны банк		
41217	Санхүүгийн бусад байгууллага		
4122	Гадаад валют	-	-

41221	Гадаадын Засгийн газар		
41222	Олон улсын байгууллага		
41223	Санхүүгийн зээл		
41224	Төслийн зээл		
41225	Бусад гадаад эх үүсвэрээс		
413	Өглөг	4,966,790.00	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	4,247,690.00	
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	719,100.00	
41330	Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг		
41340	Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг		
41350	Зээлийн хүүгийн өглөг		
4136	Бусад өглөг	-	-
41361	Байгууллагад төлөх өглөг		
41362	Хувь хүмүүст төлөх өглөг		
41363	Татварын өглөг /ТӨҮГ/		
41364	НДШ - ийн өглөг /ТӨҮГ/		
41365	Ноогдол ашгийн өглөг /ТӨҮГ/		
41366	Дансны өглөг /ТӨҮГ/		
414	Урьдчилж орсон орлого	-	-
41410	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв		
41420	Төлбөртэй ажил үйлчилгээний урьдчилж орсон орлого		
41430	Барьцаа, дэнчингийн урьдчилж орсон орлого		
41440	Бусад урьдчилж орсон орлого		
41450	Төрийн өмчийн үйлдвэр, аж ахуйн газар		
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
421	Урт хугацаат үнэт цаас	-	-
4211	Төгрөг	-	-
42111	Бонд		
42112	Бусад үнэт цаас		
42113	Бондын хөнгөлөлт		
4212	Гадаад валют	-	-
42121	Бонд		
42122	Бусад үнэт цаас		
42123	Бондын хөнгөлөлт		
422	Урт хугацаат зээл	-	-
4221	Төгрөг	-	-
42211	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв		
42212	Хувь хүмүүсийн зээл		
42213	Сургалтын төрийн сангийн зээлийн өглөг		
42214	Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн зээл		
42215	Монгол банк		
42216	Арилжааны банк		
42217	Санхүүгийн бусад байгууллага		
4222	Гадаад валют	-	-
42221	Гадаадын засгийн газраас		
42222	Олон улсын санхүүгийн байгууллагаас		
42223	Санхүүгийн зээл		
42224	Төслийн зээл		
42225	Гадаадын арилжааны банк		
42226	Бусад гадаад эх үүсвэр		
42227	ОУВС-ийн зээл		
42228	Нөөц /өр төлбөр/ /ТӨҮГ/		
42229	Хойшлогдсон татварын өр /ТӨҮГ/		
42230	Бусад урт хугацаат өр төлбөр /ТӨҮГ/		
42231	Санхүүгийн бусад байгууллага /ТӨҮГ/		
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	998,383,776.61	586,154,690.08

51	Засгийн газрын хувь оролцоо	998,383,776.61	586,154,690.08
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	324,390,884.93	324,390,884.93
51101	Өмч: - төрийн	324,390,884.93	324,390,884.93
51102	- хувийн		
51103	- хувьцаат		
51104	Халаасны хувьцаа		
51105	Нэмж төлөгдсөн капитал		
51106	Эздийн өмчийн бусад хэсэг		
512	Хуримтлагдсан үр дүн	673,992,891.68	261,763,805.15
51210	Өмнөх үеийн үр дүн	673,992,891.68	673,992,891.68
51220	Тайлант үеийн үр дүн		(412,229,086.53)
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс		
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		
51400	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
51500	Бодлогын өөрчлөлт алдааны залруулга		
51600	Нөөцийн сан		
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,003,350,566.61</u>	<u>586,154,690.08</u>

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,453,267,993.36	1,895,541,759.27
11	ТАТВАРЫН ОРЛОГО	-	-
110	Орлогын албан татвар	-	-
1100	Хувь хүний орлогын албан татвар	-	-
110001	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрх		
110002	Үйл ажиллагааны орлого		
110003	Хөрөнгийн орлого		
110004	Хөрөнгө борлуулсны орлого		
110005	Шинжлэх ухаан, утга зохиол, урлагын бүтээл тууривах, шинэ бүтээл, бүтээгдэхүүний болон ашигтай загвар зохион бүтээх, спортын тэмцээн, урлагийн тоглолт зохион байгуулах, тэдгээрт оролцож олсон орлого, тэргээртэй адилтгах бусад орлого		
110006	Урлагийн тоглолт, спортын тэмцээний шагнал, наадмын бай шагнал		
110007	Төлбөрт таавар, бооцоот тоглоом, эд мөнгөний хонжворт сугалааны орлого		
110008	Шууд бус орлого		
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-	-
110101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	-	-
110201	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татвар		
1103	ААН-ын орлогын албан татвар	-	-
110301	ААН-ын орлогын албан татвар		
1104	Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар	-	-
110401	Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар		
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	-	-
112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл		
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэл		
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл		
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл		
112005	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл		
113	Хөрөнгийн албан татвар	-	-
113001	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар		
113002	Бууны албан татвар		
113003	Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар		
113004	Малд ногдуулах албан татвар		
114	Нэмэгдсэн өртгийн албан татвар	-	-
114001	Дотоодын барааны НӨАТ		
114002	Импортын барааны НӨАТ		
114003	НӨАТ-ын буцаан олголт		
115	Онцгой албан татвар	-	-
115001	Дотоодын архи, дарсны онцгой албан татвар		
115002	Дотоодын тамхины онцгой албан татвар		
115003	Дотоодын пивоны онцгой албан татвар		
115004	Импортын архи, дарсны онцгой албан татвар		
115005	Импортын тамхины онцгой албан татвар		
115006	Импортын пивоны онцгой албан татвар		
115007	Суудлын автомашины онцгой албан татвар		
115008	Автобензин, дизелийн түлшний онцгой албан татвар		
116	Тусгай зориулалтын орлого	-	-
116001	Автобензин, дизелийн түлшний албан татвар		
117	Гадаад үйл ажиллагааны орлого	-	-
117001	Импортын гаалийн албан татвар		
117002	Экспортын гаалийн албан татвар		
118	Бусад татвар, төлбөр, хураамж	-	-
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	-	-
118001	Улсын тэмдэгтийн хураамж		
118002	Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр		
118003	Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр		
118004	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр		
118005	Агаарын бохирдлын төлбөр		
118006	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр		
118007	Ус бохирдлын төлбөр		
118008	Улсын төсвийн хөрөнгөөр тогтоосон усны нөөцийн зардлын нөхөн төлбөр		
118009	Хог хаягдлын үйлчилгээний хураамж		

118010	Ашигт малтмалаас бусад байгалийн баялаг ашиглахад олгох эрхийн зөвшөөрлийн хураамж		
118011	Бусад татвар		
1181	Газрын төлбөр	-	-
118101	Газрын төлбөр		
118102	Дуудлага худалдаа		
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	-	-
118201	Ойн нөөц ашигласны төлбөр		
118202	Ан амьтны нөөц ашигласны төлбөр		
118203	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр		
118204	Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр		
1183	Бусад татвар	-	-
118301	Бусад татвар		
118302	Нийслэл хотын албан татвар		
118303	Өв, залгамжлал, бэлэглэлийн албан татвар		
118304	Нохойны албан татвар		
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	-
120	Нийтлэг татварын бус орлого	-	-
120001	Хувьцааны ногдол ашиг		
120002	Хүүгийн орлого		
120003	Торгуулийн орлого		
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих		
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих		
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		
120005	Түрээсийн орлого		
120006	Газрын тосны орлого		
120007	Навигацийн орлого		
120008	Монгол банкны ашиг		
120009	Бусад орлого		
120010	Борлуулалтын орлого (цэвэр) /ТӨҮГ/		
120011	Борлуулалтын өртөг /ТӨҮГ/		
120012	Эрхийн шимтгэлийн орлого /ТӨҮГ/		
121	Хөрөнгийн орлого	-	-
121001	Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого		
121002	Өмч хувьчлалын орлого		
122	Тусламжийн орлого	-	-
122001	Хандив тусламж /дотоод/		
122002	Хандив тусламж /гадаад/		
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	-	-
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого		
123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого		
123003	Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг		
123004	Улсын төсвөөс орон нутгийн төсвөөс төвлөрүүлэх шилжүүлэг		
124	Зээлийн орлого	-	-
140002	Улсын төсвөөс олгосон зээл		
140003	Бусдад олгосон зээл болон урьдчилгааны эргэн төлөлт		
141001	Гадаадын санхүүгийн зээлийн эх үүсвэр		
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,453,267,993.36	1,895,541,759.27
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,377,477,470.00	1,795,391,521.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,377,477,470.00	1,795,391,521.00
131002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт		
131003	Төвлөрүүлэх шилжүүлэг		
131004	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх		
131005	Хөрөнгийн санхүүжилт		
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих		
131007	Тусгай зориулалтын шилжүүлдгээс санхүүжих		
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих		
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих		
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	75,790,523.36	100,150,238.27
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бүс этгээдээс авсан хандив, тусламж	4,627,100.00	
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл		
131103	ЗГНХ,ЗДНХХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	70,356,481.26	100,150,238.27
131106	Төсвийн урамшуулал	806,942.10	

1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	-
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/		
132002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт		
132003	Төвлөрүүлэх шилжүүлэг /орон нутгийн төсөвт байгууллага улсад төвлөрүүлэх орлого/		
132004	Оны эхний үлдэгдлээс санхүүжих / орон нутгийн төсөв/		
132005	Хөрөнгийн санхүүжилт / орон нутгийн төсөвт байгууллага/		
